

ТАВНАНГУУД ОТОГИЙН УГСАА-ГАРЛЫН ХАМААДАЛД

Б.Нацагдорж

Өгүүллийн товч утга: XVII зууны дунд үеэс эхлэн оросуудыг Байгалын өвөр нутагт нэвтэрч энэ нутгийг эзэмшиж эхлэх үес энд тавнангууд хэмээгдсэн монгол угсаатны бүлэг нутаглаж асан бөгөөд энэхүү тавнангууд хэмээгчид дундад эртний үед Бөх Бэлгүтэйн удмын ноёдод харьяалагдаж байсан авга, авганар аймгууд болохыг тухайн үеийн орос, монгол сурвалж болон аман мэдээг ашиглан тогтоож байна. Бөх Бэлгүтэйн удмын ноёд Халхын ноёдтой ураг төрлийн холбоотой болсоноос тавнангууд “хааны хүргэд” хэмээх этноним үүссэн бөгөөд энэ нь монгол сурвалжийн мэдээгээр батлагдаж байна.

Түлхүүр үг: тавнангууд отог, Бэлгүтэйн хувь улс, авга авганар, цонгоол отог, Боржигин сэцэн вангийн хошуу, Буриад монгол

Тавнангууд отгийн түүхэн угсаатны зүйн асуудалд

Монгол туургатны нэгэн хэсэг буриад-монголчуудыг угсаатны бүлгийн хувьд бүрэлдэн тогтоход тодорхой нэгэн бүлэг хүчин болж орсон Сэлэнгийн буриад нарын угсаатны бүрэлдхүүн хэсэг тавнангуудын түүхэн угсаатны зүйн асуудлыг энэхүү өгүүлэлд авч үзлээ. Бидний авч үзсэн энэ угсаатны бүлэг нь өдгөөгийн ОХУ-ын Буриад БНУ-ын Хиагтын болон Зэдийн аймагт Монгол Улсын Дундговь, Хэнтий аймагт бөөн суудаг болно.

Тухайн сэдвээр үүний өмнө орос, зөвлөлтийн эрдэмтэд нэлээд судалж буриад-монголчуудын түүхэн угсаатны зүйн талаархи ганц сэдэвт зохиолууд дотроо тусгайлан авч үзсэн зүйлсийг бичсэн байна. Дээр цагт Ар халх нэртэй байсан байгалийн өмнөх нутаг хаант оросын бүрэлдхүүнд багтах болсоноос хойш (Манж Чин улс болон Хаант Оросын хооронд 1727 онд тогтосон Буурын гэрээгээр энэ нутаг албан ёсоор оросын мэдэлд оржээ) оросын аялагч жуулчид болон элч төлөөлөгч нарын аян замын тэмдэглэл болон энэ нутгийн засаг захиргааны бичиг баримтуудад тэмдэглэгдэн, судлаачдын анхааралд орж эхэлсэн байна. Хаант оросын эзэн хааны академид алба хааж асан германы академич Симон Палласын аяллын тэмдэглэлд “Сэлэнгийн дүүрэгт оросын мунгал буюу монгол гаралтай отогууд ясак татвар төлдөг” хэмээгээд тэдний дотор Табангууд гурван отог хэмээн дурьджээ. (S.Pallas “Historische Sammlungen über die mongolischen Völkerschaften” Sankt-Petersburg 1776) Түүнээс нэлээн хожим сибирийн түүхийг судлан тусгай ном (“История Сибири” 1889 СПб) бичсэн В.К.Андреевич болон Орос-Хятадын харилцааны түүхийг судлан бичиг баримтуудын эхийг эмхэтгэн хэвлүүлсэн (“Дипломатическое собрание дел между

Российским и китайским государствами с 1619 по 1792-й год"-Казань, 1882.-С.58,533) Н.Бантыш-Каменский нарын бүтээлүүдэд тавнангуудын талаар Оросын архивын баримт материал дээр тулгуурлан, тэдний Орост дагаар орсон үйл явц орос-хятадын харилцаанд нөлөөлж байсан тухай нь өгүүлсэн байна. Хэдий тийм ч эдгээр бүтээлийг зохиогчид монгол болон тухайн үеийг судлахад шаардалга болох дорнын хэлнүүдийн наад захын мэдлэг дутмаг байснаас тавнангуудын түүх болон угсаатны нэрийдлийг зарим талаар гажуудуулсан байна. Жишээлбэл В.К.Андреевич 1689 онд Охин сайд тэргүүтэй тавнангуудын хаант орост дагаар орсон гэрээ бичиг дэхь сайд хэмээх нэр томъёог сойод хэмээх угсаатны нэртэй андуурч, тавнангуудын соёд хэмээн бичиж ойлгосон нь үзэгдэнэ. Хожим Зөвлөлтийн засгийн газрын төлөөлөгчид чухам ингэж ойлгосны улмаас энэ гэрээ бичгийг Тагна-Тувагийн тухай асуудлаархи монгол-зөвлөлтийн хэлэлцээрийн үеэр авчирч, монголын талд үзүүлж нотлохыг оролдож байсан тухай аман мэдээ буй¹.

Тавнангуудын түүх угсаатны зүйг өөрсдийнх нь аман домог болон бичгийн сурвалж дээр үндэслэн судлах эхний алхмыг Троицкосавск буюу Хиагт хотын Оросын газарзүйн нийгэмлэгийн салбарын гишүүн хаант оросын эрдэмтэн Я.Смолев хийж "Три табангутских рода селенгинских бурят-этнографический очерк" хэмээх өгүүлэл "Тр. Троицкосавско-Кяхтинского отд. Приамурского отдела ИРГО" сэтгүүлийн 1900 оны (т.1 вып) 3 дугаарт нийтэлсэн байна. Энд Смолев Хиагт орчим нутаглаж байсан тавнангууд гурван отгийн дунд удаан жил сууж цуглуулсан аман болон бичгийн материал дээр үндэслэн нэлээд дэлгэрэнгүй угсаатны зүйн найруулал бичсэн боловч тавнангуудын талаархи орос бичгийн сурвалжийг орхигдуулж, тэднийг зөвхөн 1720 онд монголоос гарч ирсэн мэтээр ташаарсан талтай байна. Үүнээс хойш зөвлөлтийн эрдэмтэд буриад-монголчуудын угсаатны түүхийг судлахдаа тавнангуудын тухай өөрсдийн бүтээлүүдэд тусгаж үзсээр иржээ. Үүнд С.А.Токарев "Расселение бурятских племен в 17 в." (Записки Бурят-Монгольского НИИЯЛИ вып.1 Улан-Удэ, 1939, стр 126-128) Б.О.Долгих "Родовой и племенной состав народов Сибири в 17 веке" М.1960 стр 320-321, Е.М.Залкинд "Присоединение Бурятии к России" М.1958 стр137-139 Г.Н.Румянцев "Селенгинские буряты" (вкн."Мат-лы по ист. и филол. Центр. Азии" М.1965 вып. 2 стр111-112) зэрэг бүтээлүүдийг нэрлэж болно. Эндээс Токарев Залкинд, Румянцев нар арай илүү бодитой судалгаа хийж нилээд үнэмшилтэй дүгнэлтүүдийг хийсэн байна. Жишээлбэл: Токарев "Тавнангууд нь угсаатны бүлгийн

хувьд нэгэн цул байсангүй олон бүлэгээс бүрэлдсэн ба энэ нь өөр гаралтай овгуудын улс төрийн нэгдэл байжээ" гэсэн нь зарим талаар хүлээж авч болохуйц дүгнэлт болохыг хойно өгүүлнэ. Б.О.Долгихийн судалгаа нь энэ дотор он цаг түүхэн баримтуудыг нэгтгэн зангидаж тавьсанаараа нилээд чамбайд орох боловч тавнангуудын гарлыг монголжсон тунгусуудтэй холбож үзсэнээр ноцтой алдаа гаргасан байна. Е.М.Залкинд Долгихийн энэ алдаатай үзлийг няцаасан боловч тавнангууд угсаатны нэр буюу этнонимийг монгол хэлний тав хэмээх тооны нэрээс үүсэлтэй хэмээн тайлбарлахыг оролдсон нь үнэмшилгүй болжээ. 1972 онд буриадын эрдэмтэн Ц.Б.Цыдендамбаев "Бурятские исторические хроники и родословные" хэмээх ганц сэдэвт зохиолдоо тавнангуудын асуудлыг нэлээд дэлгэрэнгүй авч үзэж, Залкинд болон Долгих нарын алдаатай дүгнэлтүүдийг няцаажээ. Тэрвээр оросын ууган монголчдын нэг О.М.Ковалевскийн Тавнангууд этнонимын талаар дэвшүүлсэн таамаглалыг хүлээн зөвшөөрч, энэхүү угсаатны нэрийг тавнан хэмээх феодалын цол хэргэмээс гаралтай гэж үзсэнтэй энэхүү өгүүллийг бичигч мөн санал нэгтэй байгаа бөгөөд ингэж үзэх үндэслэлийг гаргаж тавьж байгаа болно. Эдгээр судлаачид бүгд тодорхой хэмжээнд энэ угсаатны бүлгийн түүх-угсаатны зүйг улируулан үзэж, тавнангуудын гарал үүсэл тэдний буриад-монголчуудын угсаатны хувьд бүрэлдэн тогтоход ямар үүрэг гүйцэтгэсэнийг гаргаж тавихыг хичээсэн боловч үндсэн асуудал буюу тавнангуудын гарал угсаатны бүтцийн талаарх нэгдсэн ойлголтонд хүрээгүй байгаа юм. Тиймээс илтгэгч энэ асуудлыг монгол сурвалж болон урьд нийтлэгдээгүй зарим аман болон бичгийн материал дээр үндэслэн шийдвэрлэхийг зорьсон болно.

Орос, зөвлөлтийн судлаачид орос сурвалжууд дээр үндэслэн тавнангуудын тухай анхны мэдээ 1646 онд холбогдоно гэж үзэж байна. Энэ онд Дээд Ангaрын шивээгээс атаман Василий Колесников хэмээгчийн илгээсэн туршуулууд Байгалын цаадахи талд Сэлэнгэ мөрнөө монголын Турухай табун хэмээгч хүчирхэг ноён байгааг мэдээлж иржээ. Түүний дараа жил нь Иван Похабов хэмээгч түүнийг Оросын хааны мэдэлд орж алба татвар төлөхийг шаардаж тэндээсээ цаашаа Хятад руу нэвтрүүлэхийг шаардаж ирсэн бөгөөд түүнийг монголын Цэцэн ханы хүргэн бөгөөд түүний дор 20 мянган албат ард байгааг мэдэж ирсэн байна². Орос зөвлөлтийн түүхчид энэ Турухай табуныг тавнангуудын тэргүүн байсан болов уу гэж үздэг бөгөөд Цыдендамбаев бээр бас ингэж үзээд энэ нэрийг монгол хэлний Түрүү ахай тавнан

хэмээн задлаж үзсэнийг бид дэмжиж байгаа бөгөөд харин энэ хүнтэй холбогдон тавнангууд анх түүхэн сурвалжид тэмдэглэгдсэн гэх нь арай л учир дутагдалтай санагдана. Одоогийн байдлаар мэдэгдэж нийтлэгдсэн монгол сурвалжууд дотор ялангуяа халхын ноёдын гэрийн үеийн бичмэлийг дэлгэрэнгүй бичиглэж үлдээсэн “Асрагч нэртийн түүх” болон “Шар тууж” зэрэг сурвалжуудад Сэцэн хан Шолойн хүргэн Түрүү ахай тавнан хэмээх ноён харагдахгүй байгаа бөгөөд Сэцэн ханы ноёдын гэрийн үеийн бичмэлийг сайтар нягталж үзвэл олдох магадгүй юм. Тийм учраас Түрүү ахай тавнангийн тухай өгүүлэл тавнангуудын талаархи анхны мэдээ гэж үзэхгүй байна. Гэхдээ энэ асуудлыг цаашид нарийвчлан судлууртай юм. 1666 онд Сэлэнгийн шивээ буюу тухайн үеийн монгол бичиг баримтанд Сэлэнгийн байшин Цөхийн байшин хэмээн тэмдэглэгдсэн шивээ хот баригдсанаас эхлэн Халхын Түшээт хан болон Сэцэн ханы мэдэл дор байсан энэ газар нутаг Оросын мэдэлд орж эхэлжээ. 1667 онд тавнангуудын Ирким тайша хэмээгч Сэлэнгийн шивээнд элч илгээж тус шивээг өөрийнх нь мэдлийн дорхи газар дээр дураараа тавьсан учир нурааж зайлуулахгүй бол тэднийг довтолж устгана хэмээн сүрдүүлжээ³. Бидний бодлоор энэ бол хамгийн анх удаа орос бичигт тавнангууд нэр гарсан удаа болно. Түүнээс хойш 1674 он хүртэл Нэрчүүгийн шивээнд мэдэлтэй хамнигад Хилго Үдэ голоос тэдний адуу малыг хөөж аваачиж байгаа тавнангуудын тухай гомдол мэдүүлж байсан бөгөөд 1681 онд тавнангууд Түшээт ханы халхчуудын хамт Сэлэнгэ мөрөн дагуу оросын суурин гацаануудыг довтолж сүйтгэсэн байна⁴. 1681 онд Халхын Түшээт хан Чахундорж, Өндөр гэгээн нарт илгээсэн элчин Василий Турсково Сэлэнгийн шивээнээс гараад л Цөх голыг гаталтал гурван хоногийн турш тавнангуудын нутгаар явж, монголын Цэвдэн тайжийн мэдлийн нутагт орж ирсэн байна. Мөн тэдний ойр нутагт орос бичгийн сурвалжид Кукан царь хэмээн тэмдэглэгдсэн Түшээт ханы засаг Даш хунтайжийн 5 хөвүүд нутаглаж байсан байна⁵. Тэр үеийн оросын хилийн хот Селенгинскийн ойр монголчуудаас энэ хүмүүс нутаглаж асан бөгөөд хожим Халх-Ойрадын дайн дэгдэхэд эдгээр монголчууд зарим нь оросын харьяанд орж тэр үед болж асан үйл явдалд их л үүрэг рольтой оролцож явсанаас тавнангуудын тэргүүлэгчид хэмээн Цырен Цокулай, Дзяб Ирдени хоёр ноёны нэр тэр үеийн оросын баримт бичгүүдэд тэмдэглэгдэн үлджээ.

Тухайн үед эдгээр тавнангууд нь Оросын дагаар орж алба татвар төлөх шаардлагыг хүлээж авалгүй өөрийн дураар энэ нутагт нутаглаж байсан ба оросын гацаа суурингууд болон Орост дагаар орж алба татвар барих болсон буриадуудыг байнга довтолж адуу малыг нь хөөх хүмүүс олзлон аваачих зэргээр ихээхэн дайсагнасан үйл ажиллагаа оросуудын зүг хандан явуулж байсныг одоогоор мэдэгдэж нийтлэгдээд байгаа орос-монголын харилцааны баримт бичгүүдээс мэдэж болно. ("Материалы по-истории русско монгольских отношении 1685-1691" М. 2001) Албазины хэрэг явдлаас үүдэн Дайчин улстай анхны найрмадлын гэрээ тогтоохоор ирээд байсан оросын элчин Ф.А.Головин Сэлэнгийн шивээний болон бусад орос хасаг цэргүүдийн тагнуулын мэдээ, шинээр орост дагаар орогсодын мэдүүлэг зэргийг үндэслэн төв захиргаандаа явуулсан илтгэлдээ тавнангуудын тухай ингэж дурьдсан байна. *"...Сэлэнгийн болон Дагуурын шивээнээс Афонасий Пашков жанжины удирдлаган доор туршуулд явсан цэргийн албатан болон мунгал, тунгус нараас загалмайн шажинд орогсдын мэдүүлсэн мэдүүлэгд үндэслэн илтгэх нь, Сэлэнгийн шивээ орчим мунгалын табунгудын тайш нар таван хүн нутаглаж буй бөгөөд Их бага Хилго мөрнөөр Сэлэнгэ, Үдийн байшингийн хооронд тэдний нүүдлийн газар буй. Эдгээр табунгудын тайш нар нь Цөх голд цутгадаг Ерөө голоор нутагтай мунгалын Цыбден тайшийн доор мэдэлтэй бөгөөд тэрхүү Цөх гол хэмэгч нь Сэлэнгэд цутгадаг том онгоцоор гаталмаар том гол буюу. Дээр дурдагдсан Цыбден тайш нь Онон мөрөн ба Далай нуур хэмээх их нуур хүртэлхи газар нутаглан суугч мунгалын Киган хан хэмээгчийн мэдэл дор байдаг амой. Энэхүү мунгалын Киган хан хэмээгчийн доор манай Нэрчүүгийн шивээнд мэдэлтэй боловч үргэлжид урван адуу малыг хулуун өөрсдийн нутагтаа зугтаж байдаг чимчигир, пинкид болон морьтон тунгус нар багтдаг болно..."*⁶. Энэ баримтанд их тодорхой өгүүлжээ. Оросын шивээ суурингуудын хамгийн ойрын хөршүүд байсан эдгээр тавнангууд хэмээгчид хэн байв аа? Эдний тухай монгол сурвалжид тэмдэглэгдэн үлдсэн мэдээ занги байна уу? Үгүй юу? гэдгийг нягталж үзсүгэй. А.Очир, Ж.Сэржээ нарын эмхэтгэн хэвлүүлсэн "Монголчуудын овгийн лавлах"-ад одоогийн Дундговь болон Хэнтий аймгийн зарим сумдад Тавнан буюу Тавнангууд хэмээх овог байгааг илрүүлжээ⁷. Дундговьд энэ нь хуучин Сэцэн хан аймгийн Боржигин сэцэн вангийн хошуунд байсан тавнангууд отог болно⁸. Боржигин сэцэн вангийн хошуу нь

хуучин Сэцэн хан аймгийн томоохон хошуудын нэг бөгөөд Шолой Сэцэн ханы гуч Цэвдэн Галдангийн довтолгооны үеэр урагш Чин улсад дагаар орж 1691 онд Долнуурын чуулганаар Сэцэн хан аймгийн засаг, төрийн бэйлээр өргөмжлөгдөж энэ Боржигин сэцэн вангийн хошууны үндэсийг тавьжээ. “Илтгэл шастир”-ын 56-р бүлэгт **“...үүний урьд Цэвдэний харьяат хүн Цэрэн Цөхүр, Үйзэн Бурзай, Гарма гүен, Дурал тавнан тан Галданд уулгалагдуузай хэмээн айж орост эрээр одож, түшсэн бөлгөө. Үүнд хүрч ирээд мянга илүү өрхийг авч дагаар ирсэний хойно зарлигаар мөнхүү тэдэнд захиргавай.”**⁹ гэж тэмдэглэжээ. Тэгэхээр энэ Цэвдэн нь орос сурвалжийн Цыбден мөн бөгөөд дээр нэр дурьдагсад тухайн үеийн орос сурвалжид бүгд тавнангуудын сайд хэмээн тэмдэглэгдсэн бөгөөд орос сурвалжийн табунгут нь энэ Боржигин сэцэн вангийн хошууны Тавнангууд отог мөн болох нь эргэлзээгүй. Харин Галданы довтолгооноос урьд энэ Цэвдэн бээр оросын хилийн ойролцоо газраар нутаглаж асан бололтой. Гэхдээ тавнангууд нь анхандаа Цэвдэнгийн мэдэл дор байсангүй шиг бөгөөд Сэлэнгийн шивээний орчмоос адууг нь хөөж аваачсан хэргээр оросын элч нар Түшээт ханы засаг Даш хунтайжийн(орос сурвалжийн Кукан царь) хүүхдүүд дээр ирэхэд **“...тэдгээр тавнангууд нь манай албатан биш, ер хэний ч доор мэдэлгүй улс амой”** гэж тэдний адуу хөөсөн хэргийг өөрсөддөө хүлээхгүй гэж мэдэгдсэн байдаг бөгөөд¹⁰ тэдний тэргүүлэгчид нь тайша буюу тайж цол зүүж тухайн үеийн орос сурвалжуудад тэмдэглэгдсэн байдаг. Энэ мэдээг баримтлах юм бол энэ нь тухайн үеийн Ар халхын улс төрийн байдлын хувьд Халхын гурван хан, хотогойдын Алтан ханы улс болон Өндөр гэгээн зэрэг шажны том мяндагтаны шавь нараас тусдаа бие даасан хүчин халхын энэ хэсгээр байсан шиг болж таарч байна. Хэрвээ монгол сурвалжид сайтар дүн шинжилгээ, хайгуул хийж үзэх юм бол энэ тал дээр нилээд баримт олдох бололцоотой юм. 1691 онд Халх монгол Чин улсад дагаар орж Манжийн хаан хишиг тараахад Чингисийн угсааны ноёд тайж нарыг төрөлийн тайж хэмээн өргөмжилж Чингисийн дүү Бөх Бэлгүтэйн удмын ноёдыг харьяат тайж хэмээн өргөмжилж тухай тухайн хошууд дотор нь хуваан оруулж захируулжээ.

Өвөрмонголын судлаач Э.Хурцын үзэж байгаагаар энэ харьяат тайж хэмээгчид нь үнэхээр Бөх Бэлгүтэйн удмын ноёд бөгөөд Халхыг Гэрсэнз жалайр хунтайж захиран мэдэхээс өмнө өөрийн харьяат аймгийг захиран одоогийн Онон, Хэрлэн

хавиар нутаглаж XVI зууны эхээр ихээхэн хүчирхэгжиж тэргүүлэгчид нь Хан цол зүүж явсанаас Гэрсэнз жалайр хунтайж тэдний хүчийг ашиглан өөрийн эрх мэдлийг нэмэгдүүлэх гэж тэдэнтэй ураг барилдаж эхлэсэн гэжээ¹¹. Халхын түүхийг нилээн дэлгэрэнгүй тэмдэглэсэн “Шар тууж” түүхэн сурвалжид энэхүү ургийн харилцааг маш дэлгэрэнгүй харуулсан байгаа бөгөөд энд тэднийг онниудын ноёд Бөх Бэлгүтэйн удам Боржигин овогтой хэмээн тэмдэглэжээ. Дээр нэр дурьдсан Э.Хурц энэ онниудыг хожим авга авганар хэмээх болсон ба онниуд хэмээх нэршил нь Оросын нэрт монголч Б.Я.Владимирцовын оновчтой тайлсанчлан монголын Юань гүрэний үед Чингисийн дүү нарын угсааны ноёд ван(худам монгол бичгийн хэлнээ онг) цол зүүж тэдний харьяат аймаг нь онлигуд хэмээгдэж байсан нь сунжраад онниуд болсон гэсэнийг зөвшөөрч хожим онниуд нэр Хачиуны удмынханы захирсан аймагт шилжиж Бэлгүтэйн удмынхан Авга, Авганар хэмээн нэрлэгдэх болсон гэжээ. Нэгэн жишээ дурдвал Халхын Цогт хунтайжийн эх Чин тайху хатан нь Онниудын Бэрх ноёны охин байсан ба түүний шүлэгт гардаг онниудын нутагт буй Халуут авга эгч хэмээгч нь Онохуй үйзэн ноёны охин Цогт тайжийн эцэг Бахарай хошуучийн дүү Тулуй авай гэгч бөгөөд авгын Зангудай зоригт ноёны эхнэр байсан ажээ¹². Энэ ураг төрлийн харилцаа нь үнэхээр Гэрсэнз хунтайжийн бодсончлон Халхын ноёдын хүч чадлыг нэмэгдүүлж, харин авгын ноёд тэдний дагалт хүчин болж хувирсан байна. Эндээс бид орос сурвалжид табунгут хэмээн тэмдэглэгдсэн монголчууд нь дундад эртний монголын түүхэн сурвалжуудад онниуд нэрийн дор тэмдэглэгдсэн авга авганарын угсаатны бүлэг байсан бөгөөд тэдний ноёд нь халхын ноёдтой гүн бат ураг төрөлийн холбоотой болсоноор тавнан цолыг зүүж авга аймгийн нэг хэсэг нь тавнангууд хэмээгдэх болсон бололтой байна. Энэ таамаглалыг батлах нэгэн баримтыг бид манжийн үеийн монгол сурвалжаас олсон болно. Монгол улсын ТНС-ийн монгол гар бичмэл номын тасагт хадгалагдаж буй “Монгол журганаас ирсэн ба мэдүүлсэн бичгүүдийн хуулга” (шифр 2972/96 11230 34(517.3) M692) сурвалжид Халхын Сэцэн хан аймгийн Боржигины бэйл Ванжил(дээр нэр агч Цэвдэний хүү)-ын хошууны захирагч занги Муухадай нарын хүмүүс, бидний бие язгуураас Бөх Бэлгүтэйн удам тайжийн үр байтал хошуу засаг дарал барьж тэдний тайжийг эвдэж суманд оруулав хэмээн зарга мэдүүлсэн хэргийн хуулбар тэмдэглэгдсэн үлдсэн байна¹³. Үүнд Муухадай нарын гаргаж тавьсан баримт нь их сонирхол татаж буй бөгөөд манай сонирхон буй тавнангуудтай холбогдож ирж байна. Муухадайн дүү Балу хэмээгчийн мэдүүлэгт “...манай тавнангууд гэсэн учир нь

манай өвөг Санж гүений хөвүүн Сэбсэгү түшээт Мэргэн хун ноёны охиныг авсанаар тавнангууд болсон энэ билээ. Бид угаас Бөх Бэлгүтэйн удам Номи тэмээтийн хоёрдугаар хүү Бабахайн удам авга тайж нар бөлгөө"¹⁴ гэсэн байх бөгөөд үүнд манай хэлсэн таамаглалыг бүрэн баталж байна. Гагцхүү манай мэдэл дор байгаа монгол сурвалжуудад Бөх Бэлгүтэйн удмын ноёдын уг сүлжилийг нилээд дэлгэрэнгүй тэмдэглэсэн боловч Номи тэмээтийн хүү Бабахайн үрсийг цаашид нарийн тэмдэглээгүй байх бөгөөд манай улсын ТНС болон архивуудад хадгалагдаж буй харьяат тайж нарын гэрийн үеийн бичмэлүүдийг сайтар шүүн үзвээс олдох буй заа хэмээн найдна. Боржигин Сэцэн вангийн хошууны данс тэмдэглэлийг үндсэлбэл, тус хошууны Тавнангууд отогт баруун, зүүн Авга гэж хоёр овог байжээ¹⁵. Эндээс орос сурвалжуудад тавнангуудыг Түшээт ханы болон Сэцэн ханы халхчуудаас ямагт ялган тэмдэглэж байсан нь ойлгомжтой болж ирлээ. Харин эдгээр авгын ноёд тайж нар 1680-аад оны дунд үеэс эхлэн Сэцэн ханы засаг Цэвдэнгийн мэдэлд орж эхлэсэн бололтой байгаа бөгөөд өөрсдийн эрх мэдлийг алдахыг хүсээгүй авга, авганарын зарим ноёд янз бүрийн хугацаанд говийг туулан Манж Чин улсад дагаар орж Шилийн голын чуулганы 4 хошууг бүрдүүлэх болжээ¹⁶.

1680-аад онд Халхын улс төрийн байдал ихээхэн тогтворгүй болж ирээд Халхын Түшээт хан, Засагт хан хоёрын хооронд үүссэн ужиг маргаан улам даамжирч энэ нь нийт Төв Азийг хамарсан хямрал болж өсөх хүртэл хурцадсан тийм үе байсан бөгөөд Халхын Түшээт хан дотооддоо Засагт хантай муудалцаж гадна талдаа Манж Дайчин улсын алсын хараатай бодлогын өмнө балчирдсан гэнэн бодлого явуулж улам улмаар хараанд нь орж байсан ба Байгалын ар дахь буриад нутгийг оросуудад нэгмөсөн алдаад өөрсдийн уугуул Байгалийн өвөр нутгийг оросуудад алдаж байгаадаа дургүйцсэн Түшээт хан эвээр хэлэлцэж оролдоод бүтэлгүйтэх тийшээ хандмагц шууд цэргийн хүчээр шийдвэрлэхийг эрмэлзэн байсан үе билээ.

Байгалийн өвөр болон ар нутгуудаар шивээ суурин байгуулж харьяат албатуудаас нь алба татвар хурааж байгааг эсэргүүцсэн олон удаагийн элчин төлөөлөгчид нь хоосон буцаж ирэх болсон¹⁷ зэргээс үүдэн оросуудыг цэргийн хүчээр шахаж гаргах бодлого баримтлах болсон Түшээт хан өөрийн бодлогодоо Сэлэнгэ орчимгоор нутаглаж байсан Цэвдэн ноёны албат тавнангууд отгийн цэргийг ашиглаж

бодлого барьжээ. Үүнд нь мөн энэ нутгийн ойр нутаглаж байсан Түшээт ханы ойр төрөл Даш хунтайжийн хөвүүдийг үүндээ оролцуулсан байна. Хар мөрний эрэг дээрхи Албазин шивээнээс болж үүссэн Чин улс болон Оросын хоорондох хямралд хоёр тал хоёулаа Халхын Түшээт ханыг ашиглахыг хичээж байсан бөгөөд оросын тал халхын ханыг манжийн талд оруулахгүйг оролдож энэ бодлогодоо Өндөр гэгээнийг ашиглахыг хичээж байсан бол Манжийн талаас (орос сурвалжийн мэдээгээр) Түшээт ханыг хатган оросын суурин шивээнүүд рүү довтлуулан холбоотноо болгох бодлого барьсан байна¹⁸. Энэ хямралд оросын харьяанд орсон газар нутаг болон тэндхийн буриад, тунгусуудыг оросууд эзэлснийг эсэргүүцэж тэднийг эргүүлж авах тал дээр Өндөр гэгээн, Чахундорж хоёр ижил байр суурьтай байсан боловч Өндөр гэгээн энэ асуудлыг тайван замаар хэлэлцэж тохиролцохыг оролдож байсан бол Чахундорж манжийн хааны амалсан тусламжинд найдан оросуудыг шууд цэрэглэн хөөхөөр санаж байсан байна. 1687 оны эцсээр дайны намтан дийлж хотогойдын Гэндэн дайчингийн дүү Гэлэг ноён хутагтын удирдсан цэрэг Таван Мундаргын уулсыг даван Түнхэний шивээг довтолж ирсэн боловч их цас унасаны улмаас уулыг давж чадалгүй буцжээ¹⁹. Зүүн гар талаас нь Чахундоржийн дүү Шидишир баатар хунтайж тавнангууд болон түшээт ханы нийлсэн хөнгөн хуягласан 5000 орчим цэргийг тэргүүлэн 1688 оны эхээр Үдийн шивээ болон Сэлэнгийн шивээг довтолж бүслэн хааж довтлох бөлөгүүд орос цэргийн зам харилцааг бүрэн тасалсан байна. Орос сурвалжийн мэдээгээр үзвэл энэ дайнд Цэвдэнгийн мэдэлд байсан тавнангуудын гурваны хоёр нь оролцжээ²⁰. Түүний хойноос Сэцэн ханы цэрэг Нэрчүү болон Тэлэмбийн шивээг довтлохоор бэлдэж байна гэсэн мэдээг оросын хасаг цэргийн туршуулууд мэдүүлж иржээ. Эдгээр цэргүүд ихэвчлэн хуучин монгол цэргийн журмаар зэвсэглэсэн байсан бөгөөд хятадаас авсан цөөн тооны буу хэрэглэж явсан ба эхэн үедээ Үдийн шивээ хавьд амжилттай байлдсан боловч Үдийн шивээг эзэлж чадсангүй Байгалыг гатлан Байгалын ар дахь шивээ суурингуудыг довтлох гэсэн нь бүтэлгүйтэж буцан Чин улстай хэлэлцээр хийхээр явж асан Ф.А.Головины тэргүүлсэн элчин төлөөлөгч нарын байрлаж байсан Сэлэнгийн шивээг бүслэн хааж эзлэхээр оролдсон боловч их бууны шуурган галд олон хүнээ алдан шивээнээс гарч ирж довтолсон орос цэрэгт ялагдаж бүслэлтээ задлан ухраад одоогийн Буриад БНУ-ын нутаг Сэлэнгийн дүүрэг дэхь Бөхөн гол дээр, Үдийн шивээнээс Сэлэнгийн шивээнд бүслэгдсэн Головин-д туслахаар гарсан орос цэргийг тосч байлдан хоёр талаас их хохирол үзжээ.²¹ Яг энэ

үеэр Галдан Бошигт хаан халхын нутагт цөмөрсөн мэдээ ирж Шидишир цэргээ аван ахдаа туслахаар ухарсан байна. Энэ үйл явдлын тухай “Цэвдэн бэйл” хэмээх нэгэн түүхэн дуу өдгөө манай улсын Хэнтий аймагт оршин сууж буй цонгоол-буриадуудын дунд нэлээд дэлгэр дуулагдаж байсан бөгөөд уг дууны үгийг сийрүүлбэл:

**“...Сэцэн хааны хошуунаасаа л зээ зээн айдаа
Сэрэглэжэ мордобоо
Сэрэглэсэн сэрэг мину зээ зээн айдаа зээ
Хоёр түмэн сэрэгтэй
Сэрэгэймнай түрүүнинь зээ
Цэбдэн бэйлэ баатар бэлэй лэ
Сабшилсагша сэлмэ мину зээ зээн айдаа зээ
Сагаан зандан барюултай
Хатхалсагша жада мину зээ
Хүрин зандан барюултай
Харбалсагша сумо мину зээ зээн айдаа зээ
Хан гаридын үдэтэй
Боро талын зүлгыё
Бусалтандаа болуужан
Болосон эдээнэйнгээ дээжыё
Манай эжы барюужа
Шара талын зүлгыё
Шалгалтандаа болуужан
Шанасан эдээнэйнгээ дээжыё
Манай эжы барюужан”²².**

Энэ дууг төрөлх нутгаа харийн түрэмгийлэгчдээс чөлөөлөхөөр цэрэглэсэн тавнангууд нар зохиосон бололтой бөгөөд хожим тэдэнтэй ураг төрөл утга соёлын хувьд ихээхэн холбогдолтой болсон цонгоол нарт дамжин дэлгэрсэн мэт байна. Дуунд хэдийгээр Цэвдэнг бэйл цолтойгоор дуулж буй боловч бид энд 1691 оны үйл явдал бус 1688 оны аян дайныг тусгасан байна гэж үзэж байна.

Манай түүх бичлэгт өнгөрсөн жилүүдийн үзэл суртлын хүлээсэнд баригдан энэ үйл явдлын тухай төдийлөн дэлгэрэнгүй бус бичсээр ирсэн ба XVII зууны сүүл

хагасаар болсон томоохон үйл явдлуудын өнгөнд дарагдан үлдээд байдаг боловч энэ нь монголчууд өөрийн газар нутгийг хамгаалж харийн түрэмгийллийг эсэргүүцэн тэмцсэн шударга тэмцэл байсан билээ. Гагцхүү Түшээт хан Чахундоржийн эхлүүлсэн Халх-Ойрадын дайн нь нийт халх монголын хувь заяаг эргүүлж халхчууд төрийн тусгаар тогтнолоо алдаж монголын энэ нутаг оросын харьяанд багтсаар үлдэхийн үндэсийг тавьсан болно. Чин улстай хэлэлцээр хийхээр ирсэн Ф.А.Головины тэмдэглэлийг үзвэл монгол цэрэг бүслэлтээ зогсоон ухарсаны сүүлээр Байгалын өмнөх шивээ бэхлэлтүүдийн цэргийг цуглуулж тавнангууд болон халхын тайж нарыг довтлохоор зэхсэн боловч Халхад болсон үйл явдалууд түүний төлөвлөгөөг түр хугацаагаар хойшлуулжээ. Түшээт ханы гол хүчин ялагдаж тавнангуудын зарим хэсэг нь Хилго голын орчим ирж буудалласаныг дээрхи Ф.А.Головин нар олж мэдээд цэргээ авч 1688 оны 9 дүгээр сард Цэрэн цөхүр тэргүүтэй тэдгээр тавнангуудыг довтлон 200 орчим хүнийг алж 1200 орчим хүн ардыг олзолжээ²³. Үүнээс өмнө оросын мэдэлд орохыг эрс эсэргүүцэж байсан тэдгээр тавнангууд одоо аргагүйн эрхэнд оросын эрхэнд орох болсон бөгөөд мөн энэ үеэр хотгойдын Гэндэн дайчин болон Түшээт ханы ойр төрөл Даш хунтайжийн хөвүүд Эрх хунтайж тэргүүтэй тайж нар Ф.А.Головины урин дуудсанаар түүнтэй хэлэлцээ хийж орост дагаар орох гэрээ бичиг үйлджээ²⁴. Халхад гарсан байдлыг далимдуулан цахарын Гүл шар хошуунаас өөрийн албат 150 сум ардыг аван Оросын зүг зугтсан Халхын Цогт тайжийн ач Охин хунтайж садан төрлийн холбоог баримтлан эдгээр тавнангуудын дунд ирж хоргодсон бөгөөд боломж гармагц оросын хаанд дагаар орж орост дагаар орохыг эсэргүүцэж байсан тавнангууд нарыг орос цэргийн хамтаар довтлолцон, тэднийг оросын хаанд дагаар оруулсан бөгөөд 1689 оны 3 дугаар сарын 12-нд Охин сайд тэргүүлэн тэдгээр тавнангуудыг төлөөлөн дагаар орсон гэрээ бичгийг үйлджээ²⁵. Энэ дундаас манжийн дарлалаас зугтаж оросын хаанд дагахаар ирсэн Охин тайж л хамгийн их ашиг олсон бөгөөд орос ноёдын хүчийг ашиглан тавнангуудын хамгийн нөлөө бүхий Цэрэн цөхүр, Жав эрдэнэ хоёр тайжийг замаасаа зайлуулж ганцаараа оросын мэдэлд орсон тавнангууд отгийг захирах болсон боловч түүний жинхэнэ албат цонгоол овгийн 150 өрхөөс бусад нь түүнд дургүй байсан мэт агаад удаа дараа монгол руу зугтахыг завдаж Цэрэн цөхүр тэргүүтэй тавнангууд нар манжид дагаар ороод бэйл хэргэм хүртсэн Цэвдэн рүү 1691 онд зугтсанаас үлдсэн тавнангуудыг 1692 онд оросын захиргаа Хилго Цөх голоос шилжүүлж Байгалын өвөр Баргажины шивээ рүү нүүлгэн

суулгах шийдвэр гаргажээ. Гэвч энэ үеэр тавнангуудын үлдсэн хуучин тэргүүлэгч Жав Эрдэнэ гэнэт босч дагалдаж явсан оросын хасаг цэргийг цохиж Охиныг барин албатынх нь хамт хүчээр авч яван монгол руу оргож Цэвдэн бэйл дээр очсон байна²⁶. Тэднээс нэг жилийн өмнө Орост дагаар орсон Эрх хунтайж тэргүүтэй монголын долоон тайж нар хүнд хүчир алба татвар оросын засаг захиргаанаас үзүүлсэн зүй бусын дарамт шахалтыг тэсвэрлэлгүй албат ардаа аван босч явсан байна. Жав эрдэнэ тэргүүтэй тавнангууд Охиныг Цэвдэн бэйлд тушааж, өөрсдөө түүний хошуунд багтан оржээ. Эднээс одоогийн Дундговь аймаг дахь Боржигин сэцэн вангийн хошуунаас байгуулсан сумд дахь тавнангууд овгийнхон гаралтай юм.

Энд нэгэн зүйлийг тэмдэглэж хэлэхэд тус хошууг Боржигин хэмээн онцлон тэмдэглэдэг нь тавнангуудын ноёд олон жил тус хошууны засаг ноёныг орлон захирч байснаас тэгж нэрийдэх болсон гэдэг мэдээ бий нь тун сонирхолтой юм²⁷. Энд бас нэгэн зүйлийг тэмдэглэхэд тавнангуудын аман зохиолын материалыг нилээд цуглуулан хадгалсан Буриадын ШУ-ы Төвийн гар бичмэлийн фонд болон одоо хир нийтлэгдсэн аман зохиолууд болон судлаачдаас амаар сурвалжлан асуухад сэлэнгийн буриадын доторхи гурван тавнангуудын дунд Хатан Бүүвэй бэйлийн домог илэрч мэдэгдээгүй байгаа бөгөөд энэ нь манай бодоход тавнангууд нар энэ домгийг үүсч зохиогдохоос өмнө 1721 онд орос руу ойж гарсан учраас тэр болов уу. Харин хожим буриад-монголын анхны тайша цол өргөмжлөгдсөн Охин тайжийн хувьд манжийн дарлал дор ахин орохгүйн тулд өөрийн элч Мөнхийг Эрхүүд нууцаар илгээж хэлэлцээр хийн 1694 онд Цэвдэн бэйлийг нас барсаны дараа түүнийг залгамжилсан бага настай Ванжил бэйлийн үед тус хошууны нутгийн зах хөвч рүү нутаглахыг зөвшөөрүүлэн улмаар Галдан Бошигтын Хэрлэнд довтолж ирэхийг далимдуулан 1696 онд өөрийн жинхэнэ албат цонгоол нарын хамт хойшоо Оросын хаанд дагаар оржээ²⁸. Үүнд илтгэгч энэ сэдвээр нэгэн сэдэвт зохиол бичиж буй тул дэлгэрэнгүй өгүүлэхгүй харин хожим 1721 онд орост дагаар орсон гурван тавнангууд отгийнхон монголоос гарч ирсэн түүхийг авч үзье. Сэлэнгийн буриадын түүхэн сурвалж "Бичихан запискэ"-д өгүүлсэнээр бол энэ гурван тавнангууд нь халхын Сэцэн хан аймгийн нутаг Онон Хэрлэнгээр өвөлжиж Биндэр нуур орчмоор зусаж байсан гэдэг бөгөөд Сэцэн хан аймгийн эрхийг барьж асан Дэлэг ноён хэмээгчийн хавчлаганаас зугтан оросын цагаан хаанд дагасан гэдэг байна²⁹. Харин орос сурвалжийн мэдээгээр бол тавнангуудын Бадан зайсан тэргүүтэй 763 хүн сэцэн хан аймгийн Гылыкпампил

гүнгийн хошуунаас 1719 онд хил даван орж ирсэн бөгөөд тэднийг Тавнангуудын Охин тайжийн доор Сэлэнгийн шивээ орчим суулгав, гэжээ³⁰. Энд нэр дурдагдаж буй Дэлэг гүн, Гылыкпампил гүн гэгчид нь Сэцэн хан аймгийн Хөвчийн жонон вангийн хошууны гуравдахь засаг ноён байсан Гэлэгбампил хэмээгч бөгөөд чухам энэ ноёны доороос эдүгээ сэлэнгийн буриадын табангууд отогийг бүрдүүлж буй тавнангууд нар гарч ирсэн байна. Яг энэ үеэр Орос-Чин улсын хооронд худалдааны хэлэлцээр хийгдэж байсан бөгөөд тавнангуудын энэ асуудлаас болж энэ хэлэлцээр тасалдаж манжийн тал тэдгээр тавнангуудын оргон зайлагчдыг буцааж өгөхийг шаардаж байсан ба буцааж өгөхгүй бол 1689 оны Нэрчүүгийн гэрээг цуцалж, цэрэг хэрэглэнэ хэмээн сүрдүүлжээ. Хоёр талын хэлэлцээр нилээд сунжирч хурцадсан үед 1722 онд Энх-Амгалан хаан нас барж оронд нь суусан Найралт төвийн үед манжийн байр суурь нилээд зөөлөрсөнөөр хоёр талын хэлэлцээр сэргэж эхлэхэд оросын талаас 1719 онд хил давж ирсэн тавнангуудын дүрвэгчидээс зөвхөн 21 нь хоёр улсын хооронд тогтсон 1689 оны Нэрчүүгийн найрамдлын гэрээг батлах үед Оросын талд байгаагүй ба бусад нь бүгд болон тэдний эцэг ах дүү нар нь Сэлэнгэ, Нэрчүүгийн шивээнд мэдэлтэй байсан байна хэмээн буцааж өгсөнгүй.³¹ Эндээс бид оросын талд үлдсэн эдгээр тавнангууд нь үндсэндээ 1689 онд Охин сайдын хамт оросын харьяанд орсон тэр тавнангуудын нэг хэсэг байсныг мэдэж болно. Харин энэ хэсэг тавнангууд яагаад чухам энэ хошууны (одоогийн Хэнтий аймгийн Биндэр сум) мэдэл дор орсныг тавнангуудын аман домгоос тодруулж болох юм. Түүнд өгүүлсэнээр тэд Ээж гүнж хэмээгдсэн хатныхаа инж болон дагалдаж энэ Дэлэг ноёны хошуунд ирсэн хэмээдэг.³² Харин Хэнтийн бусад сумдаар буй тавнан, тавнангууд овгууд нь Боржигин сэцэн вангийн хошуунаас тасалж байгуулсан хошуудаас байгуулсан сумдад илэрч мэдэгдсэн байна.

Орост дагаар орсон эдгээр гурван тавнангууд нь Хиагт хотын орчим бөөн суурьшсан бөгөөд аман аялгуу болон ёс заншилын хувьд өөрийн халх маягийн өвөрмөц онцлогийг хадгалсаар ирсэн байна.

Abstract: The article aims to clarify the origins of the *Tabunanghud* Clan, spread among the Mongols ethnic diaspora in Mongolia and Buryatia. Accordingly, this group was most likely formed during the late 16th century, separating from the *Belgutaid* lineage of the Clan of Borjigin.

Ном зүй

1. Г.Аким "Билгүүн номч Бямбын Ринчен" 1990 Улаанбаатар х.7-9.
2. Б.О.Долгих ""Родовой и племенной состав народов Сибири в 17 веке" М. 1960 стр.320-321
3. Г.Н.Румянцев "Селенгинские буряты" вкн."Мат-лы по ист. и филол. Центр. Азии" вып.2 Москва.1965
4. Б.О.Долгих ""Родовой и племенной состав народов Сибири в 17 веке" М. 1960
5. "Материалы по истории русско-монгольских отношении 1654-1685" М. 1996
6. "Материалы по-истории русско монгольских отношении 1685-1691" М. 2001 стр. 179-181
7. А.Очир., Ж.Сэржээ "Монголчуудын овгийн лавлах" Улаанбаатар 1998
8. "Этнографийн судлал" т.8 Улаанбаатар 1982
9. "Илтгэл шастир" УТНС гар бичмэл номын фонд
10. Е.М.Залкинд "Присоединение Бурятии к России" М. 1958 стр.81
11. Э.Хурц "Авга Авганар хийгээд Бөх Бэлгүтэйн харьяат улс" вкн. А.Очир.,Б.Р.Зориктуев "Төв Азийн нүүдэлчдийн түүхэн угсаатны зүйн асуудалд" Улаанбаатр 2002
12. "Шара туджи" Монгольская летопись 17 века. М. 1957
13. "Монгол журганаас ирсэн ба мэдүүлсэн бичгүүдийн хуулга" (шифр 2972/96 11230 34(517.3) М692)
14. Мөн тэнд үзмүү.
15. "Этнографийн судлал"т. 8 Улаанбаатар 1982
16. Э.Хурц дээрхи зохиол А.Очир.,Б.Р.Зориктуев "Төв азийн нүүдэлчдийн түүхэн угсаатны зүйн асуудалд" Улаанбаатар. 2002 он
17. "Материалы по-истории русско монгольских отношении 1685-1691" М. 2001 стр7-16
18. В.А.Александров "Россия на дальневосточном рубеже в 17 веке" М. 1964
19. "Материалы по-истории русско монгольских отношении 1685-1691" М. 2001 стр.120
20. "Материалы по-истории русско монгольских отношении 1685-1691" М. 2001 стр.166
21. Мөн тэнд үзмүү.
22. Ц.Гүрбадам "Их замын эхэнд" Улаанбаатар 2005 он. 34х
23. "Материалы по-истории русско монгольских отношении 1685-1691" М. 2001
24. "Сборник документов по истории Бурятии XVII век" вып.1 Улан-Удэ 1960 с.326-330
25. Мөн тэнд. с.331-333
26. Е.М.Залкинд "Присоединение Бурятии к России" М. 1958 с.82
27. "Этнографийн судлал" т.8 Улаанбаатар 1982
28. "Русско-китайские отношение в XVIII веке. 1700-1725" т.1 Москва 1972 с.67

29. "Буряадай түүхэ бэшэгүүд" Улаан-Үдэ 1992 х.121
30. "Русско-китайские отношения в XVIII веке. 1700-1725" т.1 Москва 1972 с. 20-21
31. Мөн тэнд. с. 313
32. Я.Смолев "Три табангутских рода селенгинских бурят-этнографический очерк" вкн: "Тр. Троицкосавско-Кяхтинского отд. Приамурского отдела ИРГО" т.1 вып.3 Троицкосавск 1900

Бусад сурвалжууд

- Г.Аким "Билгүүн номч Бямбын Ринчен" 1990 Улаанбаатар
- В.К.Андреевич "История Сибири" 1889 СПб
- В.А.Александров "Россия на дальневосточном рубеже в 17 веке" М. 1964
- Н.Бантыш-Каменский "Дипломатическое собрание дел между Российским и китайским государствами с 1619 по 1792-й год."-Казань,1882.
- Ц.Гурбадам "Их замын эхэнд" Улаанбаатар 2005 он
- Б.О.Долгих ""Родовой и племенной состав народов Сибири в 17 веке" М. 1960
- Е.М.Залкинд "Присоединение Бурятии к России" М. 1958
- А.Очир., Ж.Сэржээ "Монголчуудын овгийн лавлах" Улаанбаатар 1998
- А.Очир.,Б.Р.Зориктуев "Төв азийн нүүдэлчдийн түүхэн угсаатны зүйн асуудалд" Улаанбаатар. 2002 он
- S.Pallas "Historische Sammlungen ьber die mongolischen Vьlkerschaften" Sankt-Petersburg 1776
- Г.Н.Румянцев "Селенгинские буряты" вкн."Мат-лы по ист. и филол. Центр. Азии" вып.2 Москва.1965
- Я.Смолев "Три табангутских рода селенгинских бурят-этнографический очерк" вкн:"Тр. Троицкосавско-Кяхтинского отд. Приамурского отдела ИРГО" т.1 вып.3 Троицкосавск 1900
- С.А.Токарев "Расселение бурятских племен в 17 в."(Записки Бурят-Монгольского НИИЯЛИ вып.1 Улан-Удэ, 1939
- Ц.Б.Цыдендамбаев "Бурятские исторические хроники и родословные" Улан-Удэ 1972 "Этнографийн судлал" т.8 УБ., 1982